

2021 оны 03 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар: 21/06

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
 - 2.2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.
 - 2.3. ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг хэлэлцэн батлах.
 - 2.4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох.
 - 2.5. Компанийг татан буулгах эсэх асуудлыг шийдвэрлэх.
3. Компани нь сүүлжийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөн чадаагүй тул 2020 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.
4. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн дотор хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд “Өнөөдөр”, “Үндэсний шуудан” гэсэн өдөр тутмын сонин болон TV9, UBS телевизүүдээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын материал, санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт болон бусад баримт бичиг, шийдвэрийн төсөлтэй хувьцаа эзэмшигчид Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо,

Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу "Номин юнайтед" цогцолборын 5-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дээр Даваагаас Баасан гарагуудад ажлын цагаар танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудаар дамжуулан тараахыг зөвшөөрсүгэй.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу "Номин юнайтед" цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн С.Сайнбатыг томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар тооцооны нягтлан бодогч Ж.Пүрэвжаргал, гишүүдээр өмгөөлөгч Б.Пүрэвдорж, Хүний нөөцийн мэргэжилтэн П.Хишигжаргал нарыг томилсугай.
14. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх Ч.Үржинбадам, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

А.ШАГДАРСҮРЭН



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 03-р сарын 17-ны өдрийн
21/06 тоот тогтоолын хавсралт №1

ХУРЛЫН ЗАР

“ХӨВСГӨЛ УСАН ЗАМ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТҮЗ-ийн шийдвэрийг танилцуулах.
3. ТҮЗ-ийн 2021 оны зардлын төсвийг батлах.
4. ТҮЗ-ийн гишүүдийг сонгох.
5. Компанийг татан буулгах эсэх асуудлыг шийдвэрлэх.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал урьдчилан авах сүүлчийн хугацааг 2021 оны 04-р сарын 20-ны өдрөөр тасалбар болгох ба саналаа брокер дилериин компаниуд болон Нийслэлийн ХУД-ийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу “Номин юнайтед” цогцолборын 5-р давхарт ТҮЗ-ийн нарийн бичгийн даргад ирүүлнэ. Хувьцаа эзэмшигчид саналын хуудас, хурлын материал, шийдвэрийн төсөлтэй дээрх хаягаар Даваа-Баасан гарагуудад ажлын цагаар иргэний цахим үнэмлэхтэйгээ ирж танилцах боломжтой.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид хурлын өдөр цахим хуралд нэвтрэх код, зааварчилгааг 2020 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс хойш Даваа-Баасан гарагуудад ажлын цагаар дээрх хаягт өөрийн биеэр, иргэний үнэмлэхтэйгээ ирж авна уу.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Утас: 89885120

Цахим хаяг: ulziibat.jb@gmail.com

Цагийн хуваарь: Даваа-Баасан 09:00-18:00

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 03-р сарын 17-ны өдрийн
21/06.тоот тогтоолын Хавсралт №2

**“Хөвсгөл усан зам” ХК-ийн 2021.04.27-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас**

Хурал хуралдах газар /хаяг, байршил/: Хурал цахим хэлбэрээр болно.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Хувьцааны тоо : Регистр №

Хурлаар шийдвэрлэх асуудлууд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах
 - а. Зөвшөөрсөн
 - б. Татгалзсан
 - в. Түдгэлзсэн
2. Компанийн ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг батлах
 - а. Зөвшөөрсөн
 - б. Татгалзсан
 - в. Түдгэлзсэн
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив аргаар сонгох
 - а. Зөвшөөрсөн
 - б. Татгалзсан
 - в. Түдгэлзсэн

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн овог, нэр	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
Ердийн гишүүнд нэр дэвшигчид		
1	А.Шагдарсүрэн	
2	Ш.Баярсайхан	
3	С.Сайнбат	
4	А.Норсмаа	
5	Ж.Мөнхбаатар	
6	П.Баянсан	
7	М.Должин	
Хараат бус гишүүнд нэр дэвшигчид		
1	Д.Дашцэдэн	
2	Н.Отгонбаатар	
3	П.Эрдэнэболд	

4. Компанийг татан буулгах эсэх.
 - а. Зөвшөөрсөн
 - б. Татгалзсан
 - в. Түдгэлзсэн

Санамж: 1. Санал өгөгч нь өгөх саналынхаа өмнөх үсгийг дугуйлна.

1. Саналын хуудсыг балласан, засварласан бол хүчингүйд тооцно.

2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Кумулятив аргаар таны санал өгөх эрхийн нийт тоо нь таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор буюу 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

2021/ /

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд: _____